

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Цэвэгийн Гонгор	Дугаар	L045
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Баяндун
Төрсөн газар	Дорнод аймгийн Баяндун сум	Төрсөн он	1919
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Угтамтэгчинлэн хийд	Сүм хийдийн дугаар	ДОБД 029
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 4	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Дорнод аймгийн Баяндун сумын Угтамтэгчинлэн хийд

-Та Угтамын хийдэд шавилан сууж байжээ. Хэдэн наснаасаа хэд хүртлээ суусан бэ? Хийдийнхээ тухай ярьж өгөөч?

9-р ангиасаа гарчихсан . Тэгээд 1945 онд дайн дуусаад ирсэн. Харин тэгсэн чинь байдаггүй. Хундаам болчихсон байж байсан шүү. Устаад. Тэр их юмыг яаж... Баяндунгийнхан л устгасан юм байх даа. Тэднийхэн түлсэн гэж улс хэлдэг юм. Их бурханыг, том бурханыг. Баяндунгийнхан түлсэн гэж улс хэлдэг юм. Тийм сайхан, хайран юмнуудыг. Их бүтээн байгуулалт байсан юм. Үзэн ядаад тэгээд устгасан юм.

-Угтамын хийдэд хэдэн наснаасаа хэд хүртлээ суусан бэ?

9 наснаасаа 17 хүртлээ суусан. Шашны тусгай дунд чойрын ангид сурч байсан.

-Угтамын хийд хэдэн онд байгуулагдсан хийд вэ?

Аа тэрийг мэдэхгүй.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Тэр талаар сонссон дуулсан юм байна уу?

Аа мэдэхгүй. Юу ч байхгүй.

-Танаас бид Угтамын хийдийн тухай таны үзсэн харсан, сонссон дуулсан зүйлсийг сонсмоор байна?

Аа мэдэхгүй. Нэлээн тохилог л байсан гэхээс. Миний сурч байх хугацаанд тогтмол хурал ном хураад. Зургаан дацантай байсан.

-Баяндун сум маань хуучны ямар хошуу билээ?

Өө мэдэхгүй мэдэхгүй. Би Хөгний хүн.

-Хөгнө ямар хошуу байна?

Тэрнийг би бас мэдэхгүй.

Охин нь- Хөгнө гэдэг чинь Сэргэлэн сум шүү дээ. Та нөгөө нэг хийдийнхээ юуг. (Гонгор гуай үргэлжлүүлээд ярив.)Сэргэлэн сумын эрэгтэйчүүлийн 80% нь одоогоор ярихад тэр хийдэд лам байсан юм. 300-аад байсан юм гэнэ лээ. (Угтамд сууж байсан лам нарын тоог хэлсэн.) Би номон дээрээс харсан. Хүүхэд байхад хэд ч байсан юм сонирхдоггүй. Ердөө цав манзны шавхруу идэж уугаад л явж байдаг байсан.

-Тэрийг бичиж тэмдэглэж байсан юм байгаа юу?

Байхгүй. Юу ч байхгүй. Яалаа гэж байхав. Сонирхолгүй болсон. Би яахав мэдэхийгээ л хэлээд өгье.

-Угтамын хийд маань нэлээд эртний түүхтэй эрт байгуулагдсан хийд байх нь. Хэдэн онд байгуудагдсан юм бол?

Аа мэдэхгүй, мэдэхгүй. Тэрийг мэдэх хүн гэж одоо байдаг юм уу? Энэ суманд тэнд сурч байсан хүн надаас өөр байхгүй байгаа юм. 9 жил сурсан.

-Угтамын хийд хэдэн дугантай байсан бэ?

За одоо мэдэхгүй ээ. Би тоолъё доо. Чойр, Жүд, Дүйнхор, тэрний зүүнтээ Ламрим,оо Зод тэр зүүн урд захад байсан. Манба дацан одоо эмнэлгийн анги. Баруун урд буланд байсан. Ингээд 6 дацантай байсан байна. Дуган ч яахав зөндөө. Өндөр Майдар гэж байсан.Нэг их том бурхан дугантай, жастай байсан. Угтамын хийдийн жижиг ламынх жас том дугантай байсан. Хэнийх нь ч юм мэдэхгүй. Сэрүүн Лаврин гэж байсан.Зуны цагийн хурал хурна.

- Сэрүүн Лаврин нь Чойрынх уу? Цогчэных уу?

Өөр анги. Өөр, өөр. Гол нь л Чойр шүү дээ. Чойр, Цогчэн хоёр нэг сүмтэй юм. Тэр жалгын баруун дээр байсан. Голын том жалгын баруун дээр байсан. Чойр дацан гэдэг нь Цогчэн дуган гэсэн үг.

-Нүгнээний дуган гэж байсан уу?

Баруун нүгнээ гэж баруун хойно байсан.

-Хоёр нүгнээ дугантай байсан уу?

Би барууныг нь л мэдэж байна. Зүүн гэж байгаагүй байх аа. Баруунд нь сууж ч байсан.

-Дүйчэн өдрүүдэд нүгнээ сахидаг байсан уу?

Мацаг барина. Тэр нүгнээд сууж байсан. Тэгэхдээ хэдүүлээ гороо эргэнэ гэж гараад хэдүүлээ. Тэр нүгнээ чинь баруун хойно нь байсан юм. Тэгж гараад зүүн хойно нь найзындаа очоод хулгай хийгээд

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

гурилтай хоол хийж иднэ шүү дээ. Тэгж л сахилга зөрчиж байсан юм даа. Дуу хураадаг өдөр, юм иддэггүй өдөр сахилга зөрчиж махан хоол иднэ гэсэн чинь юу гэсэн үг вэ? Тэгж сахилгагүйтэж байлаа хөөрхий.

-Хийдээ тойрсон хэрмэн хашаа байсан уу?

Тойрсон юм ч гэж байгаагүй. Тус тусдаа л байсан л даа. Тус тусдаа шавар хятад хийцийн хашаатай байсан. Хэрэмтэй байсан. Зарим нь ч болсон туйпуу, зарим нь ч түүхий туйпуу байсан. Тэгээд 44 онд ирэхэд л юу ч байхгүй. 1937 онд бүтэн байхад нь би хөдөө Хөгнийн 10-р багт гарсан. Юу ч байхгүй тийм газарт. Морь унаж чадах ч үгүй. Эмээлийнхээ бүүрэгнээс уяулж морь унаж сурч байлаа.

-Дугануудын хийц нь ямар хийцтэй байсан бэ? Хятад уу? Төвд үү?

Өө, Хятад маягийн дуганууд байсан. Дандаа хятад байсан. Вааран дээвэртэй, тоосгон барилга байсан. Тэр Сэрүүн лаврин мод байсан. Зүүн талд цагаан суварга гэж байсан. Сүмтэй, жастай байсан. Жас гэдэг чинь ар тал гэсэн үг. Гал тогоотой.

-Аймаглаж суудаг байсан уу? Хэдэн аймагтай байсан бэ? Дөрвөн аймаг байсан уу?

Баруун, Зүүн гэсэн хоёр аймаг байсан. Аймгуудын дуган гэж байсан. Аймгуудын дуган цаг улирлын байдлаар хуралтай байсан. Хэдийд ч хурдаг билээ. Сайн мэдэхгүй. Баруун, Зүүн аймгийн хурал гэж нэг л улирлын чанартай хурдаг хурал байсан.

-Ер нь нийтдээ хэдэн дугантай байсан бэ? Их л олон дугантай байсан юм байна? Та бүдүүвч зургийг нь зураад өгөхгүй юу?

Оо тэр болно шүү. Тойруулаад жасынхаа зүүн талд мод тарьсан байсан. Өөр мод тарьсан айл (дацан) байгаагүй. Суварган жас. Ганжуур жас, Шүтээн жас гэж бий. Ганжуур жас, Шүтээн жас хоёроос урагш Цагаан суварга гэж байсан. Өө золиг энэ суварга гэж байна уу? Суварга байх ёстой юм шүү. Энийг нь дарчих. За боллоо. Энэ бас нэг сүмтэй. Нийлээд 10-аад болж байна уу?

-11,12 болж байна.

Тэгвэл болж байна.

-Сэрүүн лаврин гэж байхгүй байна?

Байх ёстой. Модон барилга. Шүтээн жасын урд энд байх ёстой. Шүтээн жастай бараг цугтаа байсан. Энд сүм байгаа юм. Хоёр давхар байшин шүү. Майдар ч бас хоёр давхар барилга. Энэ бүхэн бол хийдийн ерөнхий байдал. Дуган дацангууд нь хэрхэн хаана хаанаа байрлаж байсан гээд. Энэ нэг газар ийм юм байсан гэснийг харуулж байна. Нэг том жалга. Уулын хажууд байдаг тийм л газар шүү дээ. Нэг гол чухал юм бол Могойтын рашаан. Одоо ч хүний хэрэгцээтэй байгаа.

-Айлууд нь хоёр талаараа байх уу?

Энэнээс хойш дан лам нарын орон сууц. (Зураг дээр зурж өгөв.)

-Гэр байшин алинд нь суух вэ?

Эсгий гэр, байшин аль алинд нь сууна. Энэ гэр хороолол. Эндхийн хамгийн чухал гэр хороолол бол энэ. Чойроос эхлээд энэ хүртэлх гэр хороолол. Энэ талбай бол туж гэр хороолол.

-Зодын дацангаас доошоо гэр хороолол байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Байх нь байсан. Гэхдээ олон биш.

-Тэгвэл зодод хурдаг лам нарын л гэр байх уу?

Тэр нь хамаагүй. Хаанаас ч хамаагүй сууна л даа.

-Зодод хурдаг лам олон байсан уу?

Цөөхөн байсан. Манбынх ч ялгаагүй цөөхөн байсан. Ингээд айлууд байсан. Хүрээний гадаа л байхгүй. Судраа үүрээд л явна. Рашааны баруугаар ч айл байна. Гороо тэр айлуудын баруугаар гарна. За за ер нь ингээд болж дээ.(Зургаа хэлж байна.) За баруун Нүгнээ хаана байна? Аа энэ. Энд хуралд хураад ийшээ гараад сунаж мөргөнө. Сунаж мөргөх гэж биеэрээ мөргөөд явна. Тэгээд энд ирж гурилтай хоол хийж иднэ.Сахилгагүй нь тэр.

-Өөр суврага байсан уу? Баруун хойд дээр, давааны оройд нэг. Зүүн урд дээр нэг суварга. Хоёр суварга байсан. За одоо ёстой гүйцээ. Давааны орой дээрх суваргыг тойрч гороолж л байлаа.

-Хүрээнд нийтдээ хэдэн лам сууж байсан юм бэ?

Мэдэхгүй ээ. Номон дээр 300 гаран гэж бичсэн байсан. Би мэдсэн дуулсан юм байхгүй.

-Одоо хурлуудын талаар? Ямар ямар хурал хурах үед бүх дацан нээж хурдаг байв?

Цогчэн дацанд л бүгд хурдаг байсан. Бүгдээрээ нийлж хурна. Хөдөө гадаанаас ирсэн харагчуу лам нар хүртэл л хурна.Өглөө бүр цогчэн хурна.

-Чойрт шаржин гэж хурдаг байсан уу?

Чойр дацанд хурж л байсан гэхээс ямар хурал хурж байсныг мэдэхгүй байна.

-Бусад дацангууд ямар хурал хурах вэ?

Өөрийнхөө мэргэжлийн шугамаар хурдаг байсан гэхээс өөр юм мэдэхгүй. Би чойрын хүн.

-Танай зиндаа хэдэн ламтай байсан бэ? Та юу үзэж байсан? Аль зиндаанд явав?

За байзаарай. Зиндаагаа мартчаад байна. Ингэс хийгээд орж ирнэ. Хадаг, шидүв, дүйврин,дагриг, дондонжү,ог, гом, гавдамба. Гавдамбын горимд орж чадаагүй юм даа.

-Та парчингийн гавдамбад орсон юм уу?

Гавдамбын горимд орж чадаагүй юм даа. Хадаг, шидүв, дүйврин,дагриг, дондонжү,ог, гом, гавдамба. Энэ бол чойрын анги. Ноль гээд анги улирахгүй. Сайн гээд түрүүлэхгүй. Жил болгон дэвшээд явна. Тийм юм.

-Танай зиндаа хэдэн ламтай байсан бэ?

Долоон ламтай байсан.

-Танай зиндааны багш хэн гэдэг хүн байв?

Би лам нь байсан.

Жорвон нь уу?

Үгүй ээ. Практик хийдэг юм. Аль зиндаанд юм бэ дээ.7-р ангид бил үү дээ. Тэрийг мэдэхгүй байна. Лориг гэдэг хуралд хурж байсан. Гэхдээ хэн нь ямар хариуцлагатай байх вэ гэдгийг сугалаагаар сугалж сонгодог байсан. Би ламтаж байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Унзад нь Ойжгий Шагдарын Данзан гэдэг болсон.Тэр чинь практик хийхэд нэг нь лам нэг нь унзад, нэг нь гэсгүй болно шүү дээ. Би ламтаж байхдаа жишээ нь та нар хурлын юуг мэднэ шүү дээ та нар.Зүүн талын эхэнд шар торгон олбогон дээр сууж байлаа.

-Тэр юуны хурал юм бэ?

Лоригийн практикийн хурал.

Танай зиндааны жорвон хэн гэдэг хүн байсан б?

Ойжгий Шагдарын Данзан гэдэг хүн байсан.

Танай зиндааны багш хэн гэдэг хүн байв?

Зиндааны багш гэж байхгүй.

-Тэгээд та нар хэнээр яаж номоо хөтлүүлдэг байсан бэ?

Багшийг ч яахав. Тус тусдаа багштай байдаг байсан. Янз бүрийн багштай байна. Би дөрвөн багштай байсан. Нэг нь сахилын багш. Хэв журам алдахгүй гэж энэ шашны төлөө, миний төлөө зүтгэнэ. Нэг багш нь өөрийн сууж байсан тогоо шанагыг нь барьж байсан Молом гэдэг багш байна. Мөн Равсал гэдэг багш байсан. Тэгээд номын багш Чоймбол жорвон гэдэг хүн байсан. Жишээ нь өөр дээрээ яривал ийм дөрвөн багштай байлаа.

-Тэгээд одоо гэвш дом тавихад гавдамба, дондонжу дээр тавих уу?

Гэвш болж үзээгүй. Харин тэгээд тэр 10-р анги төгсч л гэвш болдог байхгүй юу. Би 9-р ангиас гарсан даа. Миний үзсэн нэг зүйл бол сугалаагаар ламтаж үзсэн. Хурлын зүүн голын эхэнд сууж үзсэн юм. Тэгээд тэндээ хурал удирдаж байгаа лам хүн чинь Овоо уншсан.Ёндонцогний уншсан.Ёндонцогний гэндэн ба намж.... Ёндонцогний жалба бараадан.....гээд. Үхтлээ цээжлээд. Ганцаараа уншина. Бусад нь чимээгүй.

- Цогломд нь тэгээд наад хэд нь босох уу?

Цоглом гэдгийг чинь гэсгүй хүн захирал хийдэг юм.

-Овоо уншсаны дараа маань татаж Цогломд босох уу? Цоглом яасан бэ? Ерөөл дээр.

Гэсгүй урдаар яадаг юм. Овоо уншихаас өмнө цогломддог юм.

Тэр чинь бүр өмнө. Овоо уншихаас өмнө цогломддог юм. Одоогоор бол чөлөөт шүүмжлэл. Тэр чинь дандаа хэв журмын зөрчил, сахилга батын тухай. Тэрний дууссаны хойно ерөөл гэж гэсгүй чинь нэг үг хэлнэ. Юу гэлээ. Тэнгэр сэлт, амьтан бүхний оройн чимэг бологсон Бурханы шажнаар гийгээд ялангуяа 8-р Богд лам Зонховын судар тарнийн хиргүй шажин, буман нарны гэрэл мэт сацран дэлгэрээд энэ тэр гээд л учиргүй юм уншина л даа. Тэрнээс хойш Овоог нь уншина. Тэгдэг байсан. Бараг л тийм байсан. Монголоор тэгж ерөөл хэлнэ.

-Чойр дацандаа гавжийн дом тавьж байсан уу? Лхаарамбын дамжаа барьж байсан уу?

Үгүй ээ, үгүй би яалаа гэж.

-Ер нь танай хийдэд. Өөр лам нар.

Бололгүй яах юм.

-Хэдэн зиндаа байсан. Чойрт?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Өө, чөтгөр бүү мэд. Одоогоор бол ухаандаа онолын тэмцээн болж байсан байх нь. Нэг л их алга ташиж өрөөсөн хөлөө дэвсэлдэг байсан.

-Дагсал хаях?

Тийм дагсал хаях.

-Та овоогоо дахиад нэг уншаач?

Ёндонцогний гэндэн ба намжа Ёндонцогний жалба бараадан...

Би улаан комунист хүн.

-Яагаад?

Ерөөсөө шашны үзэл суртлыг ердөө хаячихсан хэрэггүй гээд. 1945 онд цэргээс ирэхдээ улаан комунист шашныг үзэн ядчихсан тийм хүн ирсэн байгаа. Хөдөө. Хөгнийн 10-т.

-Тэр цаг үе нь тийм байсан юм чинь дээ?

Онолын сургаалын шаардлага тийм байсан юм чинь.Тэгээд л ерөөсөө хаячихсан. Шашингүй амьдарч болох л юм байна. Хэрэггүй гээд.Бурхан бол байгаль ертөнцийн жам ёсноос хэтэрсэн ертөнцийн хоосон санааны тусгал гэж Марксизмд сургасан байдаг биз дээ.

-За энэ яахав. Одоо хийдийнхээ тухай ярилцъя. Танаас доор хэдэн зиндаа байсан бэ?

Ердөө хадаг шүү дээ. Би 9 жил сураад гарсан шүү дээ. Жил болгон нэг анги.

-Дээшээ хэдэн зиндаа байсан билээ?

Гэвш болчихлоо. 10 сахилыг сахисан байгаа биз дээ. Хичнээн жил болж байж юу хийдэг юм.

-Гавж?

Аа гавж болдог юм.Цорж болдог. Маарамба болдог.

-Манбын дацанд маарамба болох уу?

Мэдэхгүй байна.

-Жүд дацанд аграмба болж байсан уу?

Тэнд юм болж байсан. Гавж аграмба. Дүйнхорынхыг юу гэдэг билээ?

-Лхаарамба юм уу?

Лхаарамба ч гэдэггүй юм аа. Мартчихлаа.Би жүдийн багшийн гэрт байсан юм. Өөрийн хамаатан. Зиндааны нийллэг гэж болж байсан. Тэрнээс өөр юм би мэдэхгүй.

-Угтамын хийдийн гол сахиус нь ямар сахиус байсан бэ?

Гомбо сахиус. Би бас Улаан сахиусны Жамсрангийн наймд Титэг жадад тоглож байсан. Манай хийд чинь дээгүүр жааны цамтай гэж хэлэгдэж байсан юм. Шамба ниржиг гэдэг чинь 21-г нь яагаагүй шүү дээ. Ламын хийд гэдэг чинь хаана ч байсан юм. Одоогийн Чойбалсан сумын нутагт.

-Ялгуулсан ламын хийд.

Тэнд бас л Титэг жад, аа Шамба ниржиг гэдэг 21тоглож байсан юм гэнэ лээ. Хүүхдүүд.

-Ер нь хэдэн дүр гардаг байсан бэ?

Жамсрангийн 2 билүү 4 хор гарна. Их ширүүн. Азар гэж гарна. Хохимой гэж айхтар хүн аймаар юм гарна. Гол нь Дамдин Чойжоо шүү дээ. Мөн Цагаан өвгөн, Хөх өвгөн гарна.Арван хангал гарна.Лхам,

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гомбо, Намсрай, Шагж, Гонгор гээд. Хамгийн сүүлд л Чойжоо гардаг юмдаг. Тэгэхэд цам гарахад чинь хичээл заана. Бүжгийн хичээл бүтэн сар. Өглөө бүгд Чойжоо гарна. Би тэр хуралд өглөө бүр сууж байсан. Бас юу гэж бий. Бас нэг айхтар догшин. Шанага гэж.

-Шанага хэд билээ?

Шанага ес байх. Одоо тойрон сууж наадам үзэж байсан үзэгчдээс чихэр л авч байснаа мартаагүй байна. Хоёр гурван чихэр. Ялангуяа энэ буриадууд чинь чихэр өгөхдөө сайн байдаг юм. Баяндун, Дашбалбарынхан л Угтамын хийдэд их ирнэ шүү дээ.

-Цам жилдээ хэд гардаг байсан? Хэзээ гардаг байсан?

Ердөө ганц. Зун гардаг байсан.

-Тэр нь зуны аль сард гарах вэ?

Аа мэдэхгүй. Тэрийг би мэдэхгүй юм.

-Хамгийн сүүлийн цам 37 онд гарсан уу?

Хэн мэдэхэв. Мэдэхгүй юм.

-Та хэдэн жил цамд гарсан бэ?

2,3 жил лав гарсан байх аа. Чойжоо хурна. Тэгэхгүй бол цамд гарахгүй. Тоглож ч болохгүй. Биед хор шар болно. Хуралд суугаагүй бол хор шар болно. Тэгж бурханыг элэглэн тоглож байхад чинь хуралд нь суугаагүй бол болохгүй.

- Угтамын хийдийг анх үүсгэн байгуулагчийн тухай?

Тэрийг би мэдэхгүй. Миний анх сууж 9 настай ороход л жигтэй гоё хийд байсан.